



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 67297

Улаанбаатар хот

Н.Эрдэнэцэцэгт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Дүнжингарав нэгдсэн төвийн улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгч Нэргүйн Эрдэнэцэцэг нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 24 дугаартай дотоод албан бичиг, хяналтын улсын байцаагчийн 2023 оны 2091 дугаартай дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Эрдэнэцэцэгт үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Н.Наранцэцэг/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

142301957